

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Ярилцлага өгөгчийн нэр	Хандмаа	Дугаар	L262
Оршин суугаа аймаг	Төв аймаг	Оршин суугаа сум	Баянцагаан сум
Төрсөн газар	Баянцагаан сум	Төрсөн он	
Ажил мэргэжил	Өндөр настан, эмэгтэй		
Лам байсан эсэх, Шавилан сууж байсан сүм хийд	Жасаа хурал	Сүм хийдийн дугаар	ТӨБЦ 030
Одоогийн сүм хийд		Сүм хийдийн дугаар	
Ярилцлага авсан он сар өдөр	2007 оны 8-рсарын 15	Ярилцлага авсан хүн	Жужа

### Төв аймгийн Баянцагаан сумын Жасаа хурал

Хандмаа: Мэдэх юм байхгүй дээ. Энэ дээшээ л нэг хоёр байшин харагддаг юм. Шувуу өндөглөөд л...

Энхбаяр: Хэдэн байшин?

Хандмаа: Ганц байшин харагдаж байсан юм. Энэ Аман шандын хойд дээр байсан юм.

Энхбаяр: Хэдэн км бол, хойшоо барагцаалбал 100?

Хандмаа: Ойрхон.100 хүрэхгүй ээ, ойрхон. Тэр бол мэдэгдэх юмгүй, шаазан маазан юмын л жаахан юм байх юм билээ гэж ярих юм.

Энхбаяр: Тогтсон лам нар байсан юм болов уу?

Хандмаа: Мэдэхгүй ээ.

Энхбаяр: Сонссон юм байхгүй юу?

Хандмаа: Байхгүй.

Жужа: Дуган нь хашаан дотор байсан уу?

Хандмаа: Байгаагүй ээ, тэр буулгаад авааччихсан хойно нь л нэг дуган харагдаж байсан. Тэгээд л авааччихсан байх даа, хэн мэдэхэв.

Энхбаяр: Модон дуган юм уу, чулуун дуган юм уу?

Хандмаа: Мод оо, манай энд чинь туушийн дуган байхгүй ш дээ. Дээр үед дандаа мод байсан.

Энхбаяр: Худаг устай байсан юм болов уу?

Хандмаа: Урдхан энгэртээ Цанидын гол гэж байгаад тэндээ шанд байсан юм. Тэр шанднаас авна гээд л лам нар тэгээд авдаг байсан.

Энхбаяр: Энэ хойд зүлэгтийн хөндийд байсан хурлын талаар мэдэх үү?

## МОНГОЛЫН СҮМ ХИЙДИЙН ТҮҮХЭН ТОВЧООН, МЭДЭЭЛЭЛ-ЯРИЛЦЛАГА

Хандмаа: Мэдэхгүй, тэр Номтын байшин гэж барьдаг байсан гэж ярьдаг байсан ш дээ. Тэр чинь бас зүлэгтэйн эхэнд байдаг л байсан юм гэнэ лээ. Номтын байшин одоо туурь нь бий байх аа.

Энхбаяр: Тэнд хэдэн туурь байдаг гэсэн, тийм ээ?

Хандмаа: Аа сонирхвол харин нэлээн хэдэн туурь байгаа байх. Мэдэгдэх тийм туурь нь байдаг гэнэ үү, мантын байшин гэдэг чинь бий байх аа.

Энхбаяр: Уулынх нь байшин байсан юм уу?

Хандмаа: Мэдэхгүй.

Энхбаяр: Тэр Зүлэгтэйн хөндийдөө юм байна лээ?

Хандмаа: Мэдэхгүй. Тэр Зүлэгтэйн бүлгийн эхэндээ байсан юм уу, би мэдэхгүй. Хаана ч байсан юм, харагддаг л байсан. Олохоо ч мэдэхгүй.

Энхбаяр: Хэдий үеэс харагдахаа больсон юм?

Хандмаа: Тэгээд буулгасан юм байгаа биз, ганц байшин л байгаад л байсан. / охин нь бид нар тэгэхэд хэдий настай байсан юм гэхэд насгүй байсан байлгүй гэж хөхрөлдөв / Хүүхэд байхгүй байсан байлгүй.

Энхбаяр: Тавин оноос л өмнө юм байна тийм ээ?

Хандмаа: Тийм байх аа. Мэдэхгүй.Эхэн овоог тахиж байсан юм уу, мэдэхгүй.

Энхбаяр: Эхэн овоо гэж аль юм?

Хандмаа: Тэр шовх харын хойд талын хар.

Энхбаяр: Энэ Зүлэгтэйд Өвгөн хөх овоо гэж байна үү?

Хандмаа: Тэр чинь болохлээр энэ Баян эргийн урд, Өвгөн цагаан овоо гэж бий. Овоо нь болвол энүүхэн наана тэр Баян эргийн урд бий. Зүлэгтэйгээс нааш нь байх аа.

Энхбаяр: Номтын хийдийн байшин гэдэг чинь тэр Зүлэгтэйн жас юм биш үү, амныхаа, бүлгийнхаа өмнө байгаа өмн үү?

Хандмаа: Цагаан овоо нь тэгвэл ойролцоо байгаа.

Энхбаяр: Номт гээд байгаа чинь Зүлэгтэйгээсээ тусдаа юм үү?

Хандмаа: Тэр зүгээр л байшин байсан юм. Одоо ч гэсэн байшингийн юм байдаг юм биш үү, айлуудын байшин.

Энхбаяр: Жас хурал биш үү?

Хандмаа: Тэр Өвгөн цагаан овоо гэдгийн жас л байсан юм гэнэ лээ.Энд л тахигдсан, манай сумынх чинь энэ Өвгөн цагаан овоо, хоёр гурван овоог тахисан гэсэн.

Энхбаяр: Тэр Номтын байшинг чинь очиж үзмээр юм байна.